

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 09 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 245

Улаанбаатар хот

Г Хорооны 2008 оны 180 дугаар тогтоолоор Ү
батлагдсан журамд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.5, Хоршооны тухай хуулийн 8.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 180 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын 2.2 дахь заалтын “Хоршооны гишүүдэд олгосон зээлийн багцад Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 459/207 тоот тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам” болон уг журамд 2006 онд оруулсан өөрчлөлт (хамтарсан 147/94 тоот тушаал)-ийн дагуу ангилал хийж, эрсдэлийн сан байгуулна” гэснийг “Хоршооны гишүүдэд олгосон зээл, бусад активд Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 дугаар тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу ангилал хийж, активын эрсдэлийн санг байгуулна” гэж өөрчилсүгэй.

2. Журамд өөрчлөлтийг оруулж олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т даалгасугай.

3. Энэхүү журмын өөрчлөлтийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Хоршооны дарга, Гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН